

Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан “Сурах бичиг” төсөл

Төслийн үндсэн зорилго:

Төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээний хүрээнд алслагдсан аймаг сумдын сурагчдад ном сурах бичгийг хурдан шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг сайжруулахад төслийн зорилго оршино.

Төслийн үндсэн зорилт:

- Алслагдсан аймаг сумдад сурах бичиг эзэндээ очих процессыг тогтоон гажуудал хаана байгааг илрүүлэх
- Сурагчид сурах бичиг ашиглаж чадахгүй байгааг шалтгааныг тогтоох
- Сургуулийн номын сангаар / эрхийн бичгээр / олгогдож буй сурах бичгийн хангамж хүрэлцээг тогтоох

Хамарсан хугацаа болон хүрээ, байршил

“Сурах бичиг” төсөл нь 2006.12.01 - 2007.05.01 хүртэл 5 сар хэрэгжсэн бөгөөд төслийн хүрээнд Дорнод аймгийн төвийн 4 сургууль болон хамгийн алслагдсан Сүмбэр сум, Халхгол баг, Хөлөнбуйр, Булган сумын дунд сургуулиуд хамрагдсан болно.

Мониторингийн багийн бүрэлдэхүүн:

Төслийн зохицуулагч	П.Одончимэг / ЛЭОС-ын гүйцэтгэх захирал /
Төслийн ажилтан	П.Энхжаргал / ЛЭОС-ын хөтөлбөрийн ажилтан/ Б.Эрдэнэчимэг / ЛЭОС-ын Орон нутаг хариуцсан Д.Бүжин / ЛЭОС-ын Дорнод аймгийн салбарын

Мониторингийн аргачлал

Төслийн хүрээнд сурах бичигтэй холбоотой гарсан тогтоол шийдвэртэй танилцахаас гадна сурах бичиг сурагчиддаа очих процессыг тогтоож, тоон ба чанарын аргыг ашиглан судалгаа хийж мэдээлэл цуглууллаа.

Тоон арга:

Статистик арга:

Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас гаргасан статистик үзүүлэлтүүд, үүнд Дорнод аймагт сурч буй сурагчдын тоо болон энэ жилд захиалсан нийт сурах бичгийн тоон үзүүлэлтүүдийг олж ашиглав.

Анкетын арга:

Аймгийн төвийн 4 сургууль, Сүмбэр сум, Халхгол баг, Булган сум, Хөлөнбуйр сумын нийт 8 сургуулийн 76 багш, 556 сурагч, 62 эцэг эхийн төлөөллөөс анкетын аргаар судалгаа авлаа.

Түүврийн арга:

556 сурагчдаас судалгаа авахдаа 6-р ангиас эхлэн судалгааны асуулт бөглөх боломжтой гэж үзэн, 6 дугаар ангиудыг төлөөлж нэг ангиас авах байдлаар 6А, 7Б, 8В, 9Г гэх мэтээр түүвэрлэсэн болно.

Чанарын арга:

Ажиглалтын арга:

Дээрх сургуулиуд дээр очиж ажиллахдаа тухайн өдрийн нэг ангийн хичээлийн процесстэй танилцан хэрэглэж буй номыг нь сурагчдаар өргүүлэх байдлаар /хэрэглэгдэж буй сурах бичгийн тоог сурагчдын тоотой харьцуулах байдлаар/ нэг сургуулийн 5-6 бүлэгт дээрх аргыг хэрэглэн баримтжуулав.

Ярилцлагын арга

- Дээрх сонгон авсан сургуулиудынхаа захирал, номын санчтай , тус тус ганцаарчилсан ярилцлага
- Хэвлэлийн компаний гэрээт борлуулагчтай / Эдмон / ганцаарчилсан ярилцлагыг тус тус хийлээ.
- Аймгийн төвийн сургуулийн багш, нийгмийн ажилтан, номын санч, захирал, боловсрол соёлын газрын дарга гэх мэт хүмүүсийг оролцуулсан нийт 16 хүнтэй фокус ярилцлага зохион байгууллаа.